

**“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН АВИЛГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2023 оны 01 дүгээр сарын ... -ны өдөр

Авилгатай тэмцэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв.

№	ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	ХИЙГДЭХ АЖИЛ	ХУГАЦАА	ХАРИУЦАХ ЭТГЭЭД	БИЕЛЭЛТ
1	Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтны ХАСУМ-ыг хянасан байдлыг үндэслэн томилгоо хийх.	Шинээр томилогдохоор нэр дэвшиж буй хүний ХАСУМ-ыг АТГ-т хүргүүлэн хянуулна.	Тухай бүр	Хүний нөөц, сургалтын хэлтэс	ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар томилогдохоор нэр дэвшсэн Ц.Цацрал, Суурь бүтцийн газрын даргаар томилогдохоор нэр дэвшсэн Ц.Түвшинбаяр, ЗУГ-ын даргаар томилогдохоор нэр дэвшсэн Д.Сэрээдорж, М.Гансэлэм, Худалдан авах ажиллагааны хэлтсийн даргаар томилогдохоор нэр дэвшсэн Л.Гүрдорж нарын урьдчилсан мэдүүлэг, мэдээллийг АТГ-т хүргүүлж дүгнэлт гаргуулсан.
		АТГ-аас ХАСУМ-ыг хянаж, дэмжсэн нэр дэвшигчийг эрх бүхий албан тушаалтнаар томилно.	Тухай бүр	Хүний нөөц, сургалтын хэлтэс	АТГ-аас ХАСУМ-ыг хянаж, дэмжсэн нэр дэвшигчийг эрх бүхий албан тушаалтнаар томилж байна.
2	Авлигын эсрэг хуулийн 4.1.3, 6.1.8, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4.1, 24.1.5-д	Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын ХАСХОМ-ыг хуульд заасан хугацаанд гаргуулан цахим системд бүртгэх ажлыг зохион байгуулах.	I улиралд	Захиргаа, эрх зүйн хэлтэс	“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтнуудад 2021 оны ХАСХОМ гаргах талаар мэдэгдэж нийт 23 хүнээс ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд шалган хүлээж авах ажлыг гүйцэтгэж, баталгаажуулсан байна.

	заасныг хэрэгжүүлэх.	Холбогдох тайлан мэдээг гаргаж АТГ, ЭТТ ХК-ын эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх.	I улиралд	Захиргаа, эрх зүйн хэлтэс	“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтнуудын ХАСХОМ-ын болон ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл, хөрөнгө орлогод гарсан өөрчлөлтийн талаархи тайланг нэгтгэн гаргаж “Эрднэс тавантолгой” ХК, болон АТГ-т хуулийн хугацаанд хүргүүлсэн.
3	Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах ажлыг хэвшүүлэх.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тендерийн Үнэлгээний хороонд томилогдсон ажилтнууд шийдвэр гаргахын өмнө ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж хэвших	Тухай бүр	Худалдан авах ажиллагааны хэлтэс	УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар үнэлгээний хороонд орж ажилласан бүх гишүүд тухай бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн.
		Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах эрх бүхий албан тушаалтнууд шийдвэр гаргахын өмнө ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн	Тухай бүр	Эрх бүхий албан тушаалтнууд	Тендерийн үнэлгээний хорооноос гаргасан дүгнэлтийн дагуу бараа, ажил үйлчилгээ худалдан авах, гэрээ байгуулахад эрх бүхий албан тушаалтнаар нийт 110 ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг гаргуулан АТГ-ын meduuleg.iaac.mn сайтад шивж, шилэн дансанд байршуулсан.

		мэдэгдлийг гаргаж хэвших.			
4	Компанийн ёс зүйн зарчмыг тогтоож, дагаж мөрдөх	Ёс зүйн дүрмийг шинээр томилогдсон ажилтан бүрт тухай бүр нь танилцуулж байх	Тухай бүр	Хүний нөөц, сургалтын хэлтэс	“Ёс дүйн дүрэм”-ийг “Дасан зохицох хөтөлбөр”-ийн агуулгад оруулж 2022 онд 25 удаагийн сургалтаар нийт 192 цагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор онлайн болон танхимаар 644 ажилтанд танилцуулсан байна.
		Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавих, ёс зүйн зөрчлийн талаар өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэх	Тухай бүр	Ёс зүйн хороо	<ul style="list-style-type: none"> ▪ Ёс зүйн дүрмийн хүрээнд 5 инженер, техникийн ажилтнуудад сахилгын хариуцлага тооцуулсан. ▪ Ёс зүйтэй холбоотой 8 өргөдөл, гомдол хүлээн авч, ёс зүйн дүрэм, хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хянан шийдвэрлэсэн.
5	Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой өргөдөл гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах, хариуцлага хүлээлгэх	Авилга, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч хянан шалгах, шаардлагатай бол АТГ-т шилжүүлж шалгуулах.	Тухай бүр	Дотоод аудитын алба, Захиргаа, эрх зүйн хэлтэс	Тайлангийн хугацаанд авилга, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээлэл ирээгүй.
		Авилга гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн компанийн дотоод үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журам, заавар, шийдвэр, үйл ажиллагааг	Тухай бүр	Дотоод аудитын алба	Авилга гарах боломжийг бүрдүүлсэн гэж үзэх аливаа дүрэм, журам, заавар, шийдвэрийг компанийн үйл ажиллагаанд хэрэгжүүлээгүй буюу батлаагүй болно.

		өөрчлөх буюу хүчингүй болгох.			
6	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах	Тендерийн урилгыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим хуудсаар мэдээллэж байх	Тухай бүр	Худалдан авах ажиллагааны хэлтэс	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5.1.3, 21.1, 21.3 дугаар зүйлийн дагуу тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон компанийн веб сайтад тухай бүр зарлан мэдээлдэг.
		Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд мэргэжлийн холбоод, ТББ-ын төлөөллийг оролцуулах	Тухай бүр	Худалдан авах ажиллагааны хэлтэс	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47.4 дүгээр зүйлийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газартай гэрээ байгуулан ажилладаг салбарын мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөлөлийг үнэлгээны хорооны бүрэлдэхүүнд оролцуулан ажилласан.
		Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг цахим хуудсанд мэдээлэх	Тухай бүр	Худалдан авах ажиллагааны хэлтэс	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 33.2.1, 46.1.6 дагуу гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтийг, явцын мэдээллийг жилийн турш, жилийн эцсийн байдлаар худалдан авах ажиллагааны цахим системд оруулан ажилласан
7	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах	Тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төсөл, жилийн эцсийн санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд мэдээлэх	Хуульд заасан хугацаанд	Санхүү, төлөвлөлтийн газар	Тагнуулын ерөнхий газрын 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 5/953, 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 1113, 1114 болон 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 1629 зөвлөмж бичгүүдэд үндэслэн Тавантолгой-Гашуунсухайт төсөл, Холболтын төмөр замын төсөл, ТНАЛТ болон Богдхан төмөр замын төслүүдийн мэдээллийг нууцад хамааруулж байсан. Монгол улсын засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Төрийн нууцад хамрах мэдээллийг ил болгох тухай” 499 дүгээр тогтоол, Засгийн газрын онцгой бүрэн эрх төлөөлөгчийн тушаал болон Тагнуулын ерөнхий газрын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 09/527 тоот зөвлөмж бичгүүдийн дагуу шилэн дансанд мэдээллээ байршуулж байна. 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан гарсны дараа 2022 оны үйл

					ажиллагаа, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн мэдээ болон ТУЗ-ийн хурлаар 2023 оны төсвийг хэлэлцэн баталсны дараа мэдээллүүдийг шилэн дансанд байршуулна.
		Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг мэдээлэх /Шилэн дансанд байршуулах/.	Хуульд заасан хугацаанд	Санхүү, төлөвлөлтийн газар	Монгол улсын засгийн газрын тогтоол 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Төрийн нууцад хамрах мэдээллийг ил болгох тухай” 499 дүгээр тогтоол, Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгчийн шийдвэрийн дагуу 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт гарсны дараа шилэн дансны сайтад мэдээллээ байршуулна.
8	Компанийн хүний нөөцийн ил тод байдлыг хангах	Компанийн сул орон тооны зарыг цахим хуудсанд байршуулах	Тухай бүр	Хүний нөөц, сургалтын хэлтэс	Сонгон шалгаруулалтын журам-ыг 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн Гүйцэтгэх захирлын А/32 тоот тушаалаар батлуулж уг журмын хүрээнд онлайнаар 1033, цаасаар 318 анкетыг тус тус бүрдүүлсэн. Түүнчлэн 800 гаруй ажил горилогчтой 1 ба 2-р шатны ярилцлага зохион байгуулж 386 ажил горилогчийг ажлын байраар хангаж ажилласан.
		Компанийн ажилтны сонгон шалгаруулалт явуулах талаар нээлттэй зарлаж байх	Тухай бүр	Хүний нөөц, сургалтын хэлтэс	Нээлттэй ажлын байр танилцуулах зорилгоор 2022 оны 02 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан “ETT Events-2022” өдөрлөгт оролцож, 36 ажил мэргэжлийн чиглэлээр 181 ажил горилогчийн анкетын бүрдүүлэлт хийсэн. Мөн Өмнөговь аймгийн Цогтцэций суманд 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас зохион байгуулсан орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах зорилготой “ETT JOB FAIR” нээлттэй ажлын байрны өдөрлөгт оролцож Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн танилцуулга, явцын талаар сурталчлан ажил горилогчдын 48 анкет бүрдүүлсэн. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд 2022 оны 06 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Өмнөговь аймгийн уул уурхайн нэгдсэн зөвлөгөөн-2022” арга хэмжээнд оролцож, 20 гаруй ажил горилогчдын анкетын бүрдүүлэлт хийсэн. Эдгээр ажил горилогчдоос төслийн үе шат, ажил

					<p>горилогчдын мэргэжлээс шалтгаалан 15 ажил горилогчийг ажлын байраар хангасан байна. Мөн Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газартай байгуулсан санамж бичгийн хүрээнд тус аймгийн Цогтцэций сумын МСҮТ-өөс нийт 25 оюутан бүртгүүлснээс 8 оюутныг ажлын байраар хангах батламж гардуулсан. Нийгмийн хариуцлагын хүрээнд ШУТИС-ийн Механик тээврийн дээд сургуулийн 2 оюутан, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын “Дабль фиш” сургалтын төв (МСҮТ), Төмөр замын дээд сургуулийн нийт 11 оюутанг сонгон шалгаруулалтын журмын дагуу ажилд авсан. Мөн Төмөр замын дээд сургуулийн 1 оюутан (эцэг эх нь хөгжлийн бэрхшээлтэй)-д сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн ба гурвалсан гэрээний дагуу ажлын байраар хангасан.</p>
9	<p>Авлигатай тэмцэх газартай хуулийн хүрээнд хамтран ажиллах</p>	<p>Авлигатай тэмцэх газраас санал зөвлөмж ирүүлбэл биелэлтийг зохион байгуулах</p>	Тухай бүр	Захиргаа удирдлагын газар	<p>АТГ-аас ирүүлсэн зөвлөмжийн дагуу тус компанийн эрх бүхий албан тушаалтанд шинээр хамруулсан ажилтнуудыг Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, ХАСХОМ гаргах талаарх сургалтад хамруулсан.</p>
		<p>Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж байгаа сургалт, хурал зөвлөгөөнд холбогдох ажилтныг оролцуулж байх</p>	Тухай бүр	Захиргаа удирдлагын газар	<p>АТГ-ын холбогдох ажилтантай хамтран Авилга, ашиг сонирхлын зөрчлийн талаар цахим сургалт зохион байгуулж тус компанийн эрх бүхий албан тушаалтнуудыг хамруулсан.</p>